



АРИУН НАНДИН ЗҮЙЛИЙГ МЭДРЭХҮЙ

Ахлагч Д.Тодд Кристоферсон

Далын Ерөнхийлөгчийн Зөвлөл

Залуу Насанд Хүрэгчдэд Зориулсан СБС-ийн Галын Дэргэдэх Ярилцлага
2004 оны Арваннэгдүгээр сарын 4 • Бригам Янгийн Их Сургууль

Би энэ хэлэх үгээ “Ариун Нандин Зүйлийг Мэдрэхүй” гэж нэрлэснээр би ариун нандин зүйлүүдийг эрхэмлэн дээдлэхийг илэрхийлсэн болно. Нийгмийн тухайд ерөнхийд нь өгүүлбэл миний үеийнхнээс та нарын үеийнхэнд ариун нандин зүйлүүдийн мэдрэмжийг хийгээд тэдгээрийг хэрхэн эрхэмлэн дээдлэх ойлголтыг дамжуулж чадаагүй гэж хэлэхээсээ эмээж байна.

Та нарын эргэн тойронд үлэмж их хэмжээгээр байдаг муугийн жишээнүүдийн эсрэг би боломжийнхоо хэрээр тэмцдэг гэдэгт найдаж байна. Ариун нандин зүйл хийгээд ариун бүхэнд хүндэтгэлтэйгээр хариулах та нарын чадварыг улам төгөлдөржүүлэхэд та нарт тусална гэдэгт би найдаж байна.

Ариун нандин зүйлийн мэдрэмжтэй байхын ач холбогдол нь энгийн юм—хэрэв хүн ариун зүйлүүдийг дээдлэн хүндэлдэггүй бол, тэрээр тэдгээр ариун зүйлүүдийг алдах болно. Хүндэтгэлийн мэдрэмж байхгүй бол хүн харьцаа хандлагадаа бүдүүн баараг, биеэ авч явахад алгуураар хайш яайш болох болно. Бурхантай байгуулсан гэрээнүүдэд нь бат бэх суурь болдог тэр зүйлээс тэр хүн хөндийрч холдох болно. Бурханы өмнө хүлээх түүний хариуцлага суларч, улмаар мартагдах болно. Чингээд, тэрээр зөвхөн өөрийнхөө хувийн ая тухад санаа тавьж, хяналтгүй хүсэл таашаалдаа сэтгэл хангалуун байх болно. Эцэст нь тэрээр ариун нандин зүйлүүдийг тэр ч байтугай Бурханыг эс хайхардаг болж, тэгээд дараа нь өөрийгөө эс хайхардаг болно.

Нөгөө талаар ариун нандин зүйлийг мэдрэх мэдрэмжтэйгээр хүн ойлголт хийгээд үнэнд өсөн хөгждөг. Ариун Сүнс түүний олон удаагийн дараа нь байнгын хамтрагч болдог. Тэрээр ариун газруудад илүү олон, бүр илүү олон удаа очдог болж ариун зүйлүүдэд итгэмжлэл хүлээдэг болно. Увайгүй байдал, цөхрөлийн эсрэг түүний төгсгөл нь мөнх амьдрал байдаг.

Миний дамжуулахыг хүсч байгаа зүйлийн ихэнх нь чухамдаа нэг хүнээс нөгөө хүнд дамжуулж болохоор логик учир шалтгаантай юм. Энэ нь дотор талаасаа өсч хөгжих ёстой. Гэвч хэрэв би та нарт зарим зүйлийн

талаар бясалган бодоход тусалж чадах аваас, тэгвэл Сүнс та нарын дотор ажиллаж, тэгээд би, эсвэл хэн нэгэн өөр хүн ариун нандин юм гэж юу болох буюу үүнд хэрхэн хариулахыг та нарт ярих шаардлагагүй болно—та нар үүнийг өөрсдөө мэдрэх болно. Энэ нь та нарын мөн чанарын нэг хэсэг байх болно; хэрэг дээрээ үүнээс их зүйл аль хэдийн байгаа билээ.

Зарим үед үзэл баримтлалыг ойлгохын тулд, үүний эсрэг талыг авч үзэх нь тусалдаг. Эсрэг тал нь үүнийг тодруулж өгдөг. Ариун нандин зүйлүүдийг өндрөөр үнэлж, эрхэмлэн дээдлэхийн утга учир юу болохыг ойлгохыг бид хичээхдээ ариун нандин зүйлүүдийн мэдрэмж байх болон байхгүйн аль алиных нь зарим жишээг надтай хамт авч үзнэ үү.

1. Бошиглогчид ба Судар

Эхлээд бошиглогчид болон судруудын тухай асуудлыг авч үз. Өөрсдийнхөө эргэн тойронд, тэр ч байтугай заримдаа өөрсдийнхөө дотор бидний хардаг нэг зүйл бол Бурханы элчүүд хийгээд тэдний захиасуудад хөнгөн хуумгай хандах хандлага мөн. Энэ бол шинэ юм биш. Адамын үеэс хойш олон хүн Их Эзэн Өөрийн нэрээр илгээсэн хүмүүсийг үл тоомсорлож, тэр ч байтугай дайран довтолж байсан билээ. Есүс үүнийг нэг зүйрлэлт сургаалд дүрслэхдээ:

“Нэгэн газрын эзэн усан үзмийн мод тариалж, түүнийгээ тойруулан хашаа барьж, дарс шахагч сав суулгах нүх ухаж, цамхаг босгожээ, тэгээд үүнийгээ тариаланчдад түрээслээд хол аянд явж гэнэ.”

Зүйрлэлийг та нар ойлгож байгаа: Их Эзэн бидэнд зориулж усан үзмийн талбай—энэ дэлхийг бүтээсэн юм, харин бид бол Түүний оршихуйгаас салгасан мөнх бус байдал дахь түрээслэгчид буюу даамлууд юм.

“Ургац хураах цаг болоход эзэн усан үзэм авчруулахаар боолуудаа усан үзмийн тариаланчид уруу илгээжээ.”

Өөрөөр хэлбэл, Бидэнд заах болон бидний хариуцсан ажил үүргийн тайлан хүлээн авахын тулд Бурхан Өөрийн бошиглогчид болон бусад элчүүдийг илгээжээ.

“Усан үзмийн тариаланчид боолуудыг нь бариад нэгийг нь зодож, нөгөөг нь алж, гурав дахийг нь чулуугаар цохив.”

“Эзэн урьд явуулснаас ч олон тооны боолуудыг дахин илгээсэнд тэд мөн л адил ханджээ.”

“Тэвч дараа нь тэр, тэд миний хүүг хүндэлнэ гээд хүүгээ илгээв.”

“Харин тариаланчид хүүг хараад, өөр хоорондоо, Энэ чинь өв залгамжлагч байна, Ирэгтүн, түүнийг алж өвийг нь булаацгаая” гэжээ (Матай 21:33-38).

Бурханы жинхэнэ Хүү, Есүс Христийг эсэргүүцэж, тэр ч байтугай үхэлд хүргэсэн нь шүтээнийг дээд зэргээр доромжилсон хэрэг биш гэж үү? Энэ нь үргэлжилсээр л байгаа. Өнөөдөр дэлхийн олон хэсэгт Бурханы хүүг эсэргүүцэх нь өсөн нэмэгдэж байгааг бид харж байна. Түүний бурханлиг мөн чанарт эргэлзэж байна. Түүний сайн мэдээг зохимжтой биш гэж бодох болжээ. Өдөр тутмын амьдралд Түүний заадаг зүйлүүдийг үл тоомсорлож байна. Түүний нэрээр хууль ёсоор ярьдаг хүмүүс нийгмийн шашны бус хүрээнд бага хүндлэгддэг.

Хэрэв бид Их Эзэн болон Түүний үйлчлэгчдийг үл тоомсорлох юм бол бид чухамдаа шашингүй үзэлтнүүд болох болно—эцсийн үр дүн нь чухамдаа яг адил юм. Энэ нь амар амгалан хийгээд цэцэглэл хөгжилтийн үе үргэлжилсний дараа ирдэг хэвийн зүйл болохыг Мормоны Ном дүрслэхдээ: “Тэгэхэд тэд зүрх сэтгэлээ хатууруулж, мөн Их Эзэн Бурханаа мартаж, мөн Ариун Нэгнийг хөл дөрөө дэвсэлдэг тэрхүү цаг үе байдаг” гэжээ (Хиламан 12:2). Ингэхлээр, Ариун Нэгнийг бас Түүний илгээсэн хүмүүсийг бид хүндэлдэг бил үү? хэмээн бид өөрсдөөсөө асуух ёстой.

Хэдэн жилийн өмнө Ахлагч Роберт Д.Хейлс тэрээр өөрөө төлөөлөгчөөр дуудагдахаасаа өмнө тэрхүү ариун дуудлагын аавынхаа мэдрэмжийг харуулсан нэг туршлагын талаар эргэн дурсжээ. Ахлагч Хейлс хэлэхдээ:

“Хэдэн жилийн өмнө Аав маань ная гаруй настай байхдаа, өвлийн нэгэн цастай хүйтэн өдөр Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын нэг гишүүн түүнтэй ирж уулзахыг хүлээж байлаа. Зураач аав маань тэр Төлөөлөгчийн гэрийг зурсан байв. Зургийг түүнд хүргэж өгөхийн оронд тэр сайхан зантай Төлөөлөгч зургийг өөрөө ирж авах далимдаа аавд талархал илэрхийлэхийг хүссэн ажээ. Түүнийг ирэхэд Аав бэлэн байх гэж юм бүхнээр санаа тавьж мэднэ гэдгийг тэр мэдэж байсан болохоор би тэдний гэрээр

ороод гарсан юм. Цас гүнзгий хунгарласнаас орох хаалганы өмнөх явган хүний зам дээр зузаан цасан далан тогтсон байв. Аав явган хүний замын цасыг хүрээр цэвэрлэж, зайлуулахаар хөдөлмөрлөсөн байв. Тэрээр гэртээ эргэж орж ирэхдээ ядарч, бие нь янгинан өвдсөн байлаа. Намайг ирэхэд тэр хэт их хүч гаргаснаас бас хэт их санаа тавьснаас зүрхээр нь хатгуулан өвдөж байв. Би юуны өмнө тэрхүү ухаалаг бус биеийн хөдөлмөрөөс нь түүнийг дулаацуулахад санаа тавив. Түүний хөдөлмөрийн үр дүн юу болохыг тэр мэдээгүй юм гэж үү?

“ ‘Роберт’, гэж тэрээр тасалданги амьсгаагаар хэлээд, ‘Их Эзэн Есүс Христийн Төлөөлөгч манайд ирэх гэж байгааг чи мэдэж байна уу? Явган хүний зам цэвэрхэн байх ёстой. Тэр хунгарласан цасан дундуур ирэх учиргүй’ гэж хэлэв. Тэр гараа өргөн, ‘Өө, Роберт, Их Эзэний Төлөөлөгчдийг таньдаг байж, тэдэнд үйлчлэх нь ховор тохиох онцгой боломж гэдгийг хэзээ ч бүү март’ гэж хэлж билээ (in Conference Report, 1992 оны Дөрөвдүгээр сар, 89; *Ensign*, 1992 оны Тавдугаар сар, 64).

Ийм аав төлөөлөгчөөр үйлчилдэг хүүтэй байснаараа адислагдсан нь зүгээр нэг тохиолдлынхоос илүү зүйл гэж би боддог.

“Төлөөлөгчдийн болон бошиглогчдын дуудлагыг би ариун гэж үздэг үү? Тэдний зөвлөгөөнд би буурь суурьтай ханддаг уу, эсвэл үүнийг өөрийнхөө хувьд хөнгөмсгөөр ханддаг уу?” гэж та нар өөрсдөөсөө асууж болно. Жишээ нь, Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли бусад зүйлүүдийн дотор боловсрол мэргэжлийн сургалтыг эрхэмлэн, порнографийг тахал гэж үзэн түүнээс зайлсхийх, эмэгтэйчүүдийг хүндлэх, хэрэглээний өрийг устгах, талархалтай байх, мөн өөрийн чадах хамгийн сайныг хийдэг байхыг мөн зөвлөдөг билээ.

Ах нарын сургамжилдаг зүйлийг та нар хийхийг хүсдэг гэдгийг та нарын үйл ажиллагаа харуулдаг уу? Та нар Түүний үгс хийгээд Ах Нарын хэлсэн үгсийг идэвхтэйгээр суралцдаг уу? Энэ та нарын өлсөж, цангадаг тэр зүйл мөн үү? Хэрэв тийм бол, бошиглогчдыг Бурханы Хүүгийн гэрчүүд хийгээд элчүүдийн хувьд тэдний дуудлагын эрхэм ариун чанарын тухай мэдрэмж та нар т байгаа.

Олон үеийнхний туршид бошиглогчийн албан тушаалын чухал тал нь түүхийг болон Бурханы үгийг цэдэглэх явдал байлаа. Судрууд ариун нандин юм. Нифайн ялтсууд болон бусад цэдгүүдийг

Алма Хиламанд шилжүүлж өгөхдөө, “эрхэм нандин агаад, түүний нандин хадгалсаар ирсэн . . . эдгээр зүйлийг Бурхан чамд даатгасныг санагтун, хүү минь” “. . . Чи эдгээр эрхэм нандин зүйлүүдэд санаа тавихыг мэд, тийм ээ, чи Бурханд найдан амьдрахыг мэдтүгэй” хэмээн сануулсан байдаг (Алма 37:14, 47; налуу бичлэгийг нэмэв).

Судрын үлэмж том ботиуд бидний гарт байдаг. Цэдгүүд эртний патриархийн үеэс бидний амьдардаг өнөө үеийг хүртэл хугацааг хамардаг. Энэ бол түүхэн дэх хүмүүст байснаас илүү олон судар гэж би боддог, түүнчлэн мэдээжийн хэрэг энэ нь өнгөрсөн үед байсан ямар ч судраас хавьгүй илүү хүртээмжтэй байна. Хэрэв та нар, эсвэл би Мосегийн дээр нь бичиж байсан хуйлмал эх бичгүүдийг юм уу эсвэл Мормоны сийлбэрлэсэн төмөрлөг ялтсуудыг гартаа барьж үзсэн бол, бид хүндэтгэл, гүн бишрэлийн мэдрэмжийг мэдэрч, тэдгээр зүйлүүдэд агуу их анхаарал болгоомжоор хандах байсан биз ээ. Тэдгээр нь ариун нандин зүйлүүд учраас бид ингэж хандах байсан, мөн тэдгээрийг төдий их хүч чармайлтаар бэлтгэсэн ариун бошиглогчдын хөдөлмөр болон золиослолоор үүнийг ийм болгох байсан биз ээ.

Гэвч ийм хуйлмал бичээсүүд буюу ялтсуудын хамгийн агуу үнэ цэнэ нь эдгээр зүйлүүдэд өөрт нь биш, харин тэдгээрийн агуулдаг үгст байдаг. Тэдгээр нь Бурханы үгс учраас ариун нандин юм, бид эх баримт бичгүүдийг гартаа барих боломжгүй ч гэсэн, үгсийг нь бид барьж байдаг. Тиймээс, бидэнд байгаа зүйл нь ариун—ариун бичээс юм.

Бурханы цэдэглэгдсэн үгсийг эзэмших боломжтой болсноороо бид энэхүү цэдгийг хамгаалж, эрхэм ариун мөн чанарыг нь дээдлэн хүндэтгэж байгаа эсэхийг өөрсдөөсөө асуух ёстой. Зарим хүмүүс доог тохуу болгох буюу тэдгээрийн амьдрах чадварыг үгүйсгэснээр судруудын ариун нандин чанарыг зөрчдөг. Энэ бол, мэдээж хэрэг, их ноцтой асуудал юм.

Гэвч хэрэв бид судруудын ариун нандин чанарыг үл хүндэтгэсэн ямар нэг гэм буруутай бол, энэ нь үл тоомсорлосноос болдог бөгөөд бидний олонхийн хувьд, жишиг бүтээлүүдийн ариун нандин чанарыг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байдаг билээ. Бид өдөр тутам сэрэмжлэн хамгаалж байх аюул бол ариун үг хэллэгт хөнгөн хуумгай, тэр ч байтугай тоомжиргүй хандах явдал мөн. 1832 онд Их Эзэн ахлагчдад хандан, зэмлэнгүйгээр хэлэхдээ:

“Мөн итгэлгүйн улмаас, мөн өөрсдийнхөө хүлээн авсан зүйлүүдэд та нар хөнгөмсгөөр хандсаны улмаас та нарын оюун өнгөрсөн үед харанхуйлагдсан байлаа —

“Энэхүү хоосон болон итгэлгүй байдал нь бүхэл сүмийг буруушаалт дор авчирсан буюу.

“Мөн тэд наманчилж мөн тэрхүү шинэ гэрээ, бүр Мормоны Номыг тэд миний нэрээр өгсөн урьдын зарлигуудыг зөвхөн хэлэхээр төдийгүй, харин миний бичсэний дагуу үйлдэхээр санах хүртэл тэд энэхүү буруушаалт дор орших болно гэжээ” (С ба Г 84:54-55, 57; тодотголыг нэмэв.)

Ариун нандин зүйлүүдийн мэдрэмж нь судруудыг эрхэмлэн дээдлэх, бүр хайрлахыг өөртөө агуулдаг. Ариун нандин зүйлүүдийн мэдрэмж нь хүнийг Христийн үгнээс зооглоход хөтөлдөг (2 Нифай 31:20; 32:3-ыг үз), энэ нь эргээд Түүний үгсийн төлөөх хүний хүндэтгэлийг гүнзгийрүүлдэг.

2. Хүний Бие— Бурханы Ариун Сүм

Одоо бидний сэдвийн өөр нэг жишээ, бидний биеийн ариун нандин мөн чанар уруу би орёе. Бурхан болон Христ бидний хүндэтгэл бишрэлийг хүлээдэг болохоор Тэдний үйлс бидний хүндэтгэл бишрэлийг хүлээдэг билээ. Энэ нь мэдээж хэрэг, түүний гайхамшигт бүтээлт болох энэ дэлхийг багтаадаг. Гэвч энэ дэлхий хичнээн гайхамшигтай ч гэсэн энэ нь Бурханы бүтээлүүдээс хамгийн агуу нь биш юм. Энэхүү гайхамшигт бие илүү агуу юм. Хүний бие Бурханы бие хүнтэй нэн адил төстэй юм. Бие бидний дэлхийн туршлагад зайлшгүй чухал бөгөөд бидний үүрдийн алдар суугийн түлхүүр мөн.

Манай таван хүүхэд нэг бүрийг төрөх тэр агшинд байлцсан нь миний адислал юм. Тухай бүрт, энэ бол ариун нандин туршлага байсныг би мэдэрсэн. Ямар нэг бурханлиг хийгээд гайхамшигтай зүйл болж байсан нь тодорхой байлаа. “Хэлэхэд танд амархан байгаа. Та өвдөж үзээгүй хүн шүү дээ” гэж эхнэрийнхээ хэлэхийг би сонссон л доо. Мэдээж хэрэг төрөлтэй холбоотой “үнэхээр дэлхийн туршлага” гэж бидний нэрлэж болох олон зүйл энд байж болно. Газар сайгүй байх бүх эхчүүдэд би та нарын өвдөлтийг хуваалцаагүй, үүнийг ойлгохыг ч би хичээсэн нь үгүй хэмээн дуртайяа хэлж болох л доо.

Гэвч буурь суурьтайгаар өгүүлбэл, биеийн бүтээл дэх эмэгтэй хүний зовиур тэрхүү бүтээлтийн ариун чанарт, мөн эмэгтэй хүнийг өөрийг нь нэмдэг гэж үү? Түүний золиослол аль хэдийн ариун зүйлийг улам ариусгадаг.

Зарим хүмүүс өөрсдийнхөө биеийг хүндэтгэн үзэх тухайд буруу бодолтой байдаг. Гэвч бид Бурханы өмнө хариуцлага хүлээдгийг бидэнд тусгайлан хэлсэн байдаг. “Та нарын бие бол Бурханы та нарт өгсөн, та нарын дотор байдаг Ариун Сүнсний сүм мөн гэдгийг та нар мэддэггүй юм уу?”

“Учир нь та нарыг үнээр худалдан авсан юм: тиймээс биеэрээ, Бурханых болох бодгалиараа Бурханыг алдаршуулагтун” (1 Коринт 6:19–20).

“Хэрэв хэн нэг нь Бурханы ариун сүмийг устгавал, Бурхан тэр хүнийг устгана; Учир нь, Бурханы сүм бол ариун бөгөөд энэ нь та нар юм” (1 Коринт 3:17). “Иймд, ах дүү нар аа, өөрсдийн биеэ Бурханд тааламжит амьд, ариун тахил болгон өргөхийг Бурханы өршөөлөөр та нараас хичээнгүйлэн гуйя, Энэ нь та нарын сүнслэг мөргөл юм” (Ром 12:1).

Бурханы энэхүү хамгийн чухал хийгээд эрхэм нандин бүтээлийн ариун чанарыг бид хэрхэн хамгаалах ёстой вэ? Хамгийн наад зах нь, бид өөрсдийн биеийг ямар нэг байдлаар бузарлахгүй байх ёстой. Тодруулбал, хэрэв бид ариун нандин зүйлийн мэдрэмжтэй байх юм бол, бид биеэ шивээс, цоолох зэргээр муухай болгохгүй байх сан. Сүмийн Ерөнхийлөгч энэ асуудлаар мэдэгдэл хийсэнд зарим хүмүүс гайхдаг. Энэ асуудлаарх түүний чиглүүлэл хийгээд өвөрмөц онцлогийн учрыг тэд олддоггүй. Тэрээр хэлэхдээ,

“Шивээс бол биеийн ариун сүм дээрх сараачсан зүйл юм.

“Чих, хамар, бүр тэр ч байтугай хэлээ олон цоолох нь үүний нэг адил юм. Тэд үүнийгээ гоё сайхан гэж бодож болно гэж үү? Энэ бол үеэ өнгөрөөсөн хоосон маяг, гэвч үр дагавар нь байнгын байж болно. . . . Шивээсийг түүнчлэн “анагаах ухааны зорилгоор бус бол биеийн эрхтэнүүдээ цоолохыг бид хориглодог” гэж Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга мэдэгдсэн билээ. Гэвч “эмэгтэйчүүд нэг хос буюу—хос ээмэгнүүд зүүхийн тулд чихээ жижгээр цоолохыг” бид огт эсэргүүцдэггүй (Гордон Б.Хинкли, in Conference Report, 2000 оны Аравдугаар сар, 70-71; *Ensign*, 2000 оны Арваннэгдүгээр сар, 52).

Ач холбогдол багатай мэт санагддаг зүйлүүдийн талаар Бурханы бошиглогч яагаад ярьдаг вэ? Учир нь гэвэл тэдгээр нь ач холбогдолгүй биш юм. Бурханы бүтээл Түүний ариун сүмийг бузарлах буюу муухай болгох нь ариун нандин зүйлээр элэг доог хийхэд

хүргэдэг. Үүнийг зөвхөн ариун нандин зүйлийн мэдрэмжээ алдсан хүн л ач холбогдолгүй мэтээр ухамсарлаж болно. Бүү ингэ.

Даруу бус хувцас бас хүмүүний биеийн ариун нандин чанарыг гутаадаг. Даруу биш хувцасны маяг хийгээд порнографийг зөвтгөн дэмжихэд олон санаачлага гаргасаар байна. Зарим хүмүүс үүний эсрэг хууль байхгүй учраас энэ нь буруу байх ёсгүй, ийм болохоор үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд хууль батлан гаргаж болохгүй гэж идэвхтэй нь аргагүй нотолдог.

Өөр нэг аргаа барсан санаачлагыг саяхан гаргаж, порнографийн сэтгүүлүүдэд зориулан Олимпийн тамирчдыг шалднаар харуулахад ашиглалаа. Нэгэн эрхлэгч, “эдгээр эмэгтэйчүүд . . . ер бусын биетэй бөгөөд энэ нь эдгээр биесээ ил гарган харуулах нэг боломж юм” гэж тэмдэглэжээ (in Steve McKee “An Olympic Pose Isn’t What It Used to Be,” *Wall Street Journal*, 2004 оны Наймдугаар сарын 18, A8). Чухам түүний үнэхээр хэлэх гэсэн юм, мэдээжийн хэрэг, “эдгээр ер бусын биесээс хэсэг мөнгө хийх боломж надад байна гэж би бодно” гэсэн үгс байлаа.

Ямар ч санаачлага байлаа гэсэн даруу биш байдлын жинхэнэ хөшүүрэг нь сэтгэл гижигдэлтээс ашиг олох гэсэн хэн нэгний хүсэл, мөнгөний төлөө хэн нэгний шунал байдгийг та нар олонтаа олж мэдэх болно. Хүний бие бол Бурханы ариун сүм бөгөөд порнографи болон биеэ ил гэргасан хувцас бол мөнгө хийгчид ариун сүмийг дахин гутаан доромжилж байгаагийн нотолгоо мөн.

Мэргэн Ухааны Үг болон өөр бусад олон зүйлийн талаар бид ярьж болно, гэвч эд бүгд нь биеийг бузарлагч, хамгийн хортой, хамгийн сүйрүүлэгч, үл хүндлэхээс үүдэлтэй хамгийн их зовлон учруулагч зүйл бол бэлгийн харилцааны ёс суртахуунгүй байдал, үүний нэг төрөл бэлгийн харилцааны гаж буруу дон юм.

Бурханы бүтээлийг хамгийн ариунаар нь хэрэглэхийг гутаахаас илүү ноцтой тийм бузарлалтыг хүн төсөөлж чадахгүй. Та нар ийм ямар ч зүйлийг огт хийх ёсгүй. Бүр зах сэжүүр лүү нь ч бүү ор. “Садар самуун явдлаас зугтан явагтун. . . . Садарлагч [эр] өөрийнхөө биеийн эсрэг нүгэл үйлддэг” (1 Коринт 6:18). “Идэр насныхаа дур хүслүүдээс зугт” (2 Тимот 2:22). “Бурханд ойртогтун, тэгвэл тэр та нарт ойртоно. Дяавлыг эсэргүүц, тэгвэл тэр та нараас зайлна” (Иаков 4:8). Бурханд амьд өргөл болгон өөрсдийн биеийг ариун байлга (Ром 12:1-ийг үз).

3. Ариун Газрууд болон Үйл Явдлууд

Одоо ариун газрууд болон үйл явдлуудын талаар товчхон авч үзье. Их Эзэн бошиглогч Езекиелээр дамжуулан зарим үйл ажиллагаа болон газруудын ариун нандин чанарыг хүндэтгэхийг заахад бүдэрсэн Израилын санваартнуудыг шүүмжилсэн билээ:

“Түүний тахилч нар миний хуулийг хэрцгийгээр зөрчиж, миний ариун юмсыг бузарлав: Тэд ариун зүйл болон жигшүүрийг хооронд нь эс ялган, бузар болон цэврийн ялгааг заасангүй, тэд миний хүндэтгэлийн өдрөөс нүдээ нууж, мөн би тэдний дунд жигшигдсэн юм” (Езек.22:26).

Их Эзэний ярьдаг байсан зүйлээс олон нь ариун сүмтэй холбоотой байлаа. Мөн энд Хүндэтгэлийн Өдрийн тухай дурдагддаг. Бид Их Эзэнд онцгойлон адислагдсан өөрсдийн ариун сүмүүд хийгээд цуглааны байруудыг ариун газрууд хэмээн боддог байх ёстой. Ариун сүмийн барилга бүр дээр байдаг “Их Эзэнд Ариун нь—Их Эзэний Өргөө” гэсэн үгс бол ухааруулах сануулагч мөн. Ариун нандин зүйлийн мэдрэмж нь биднийг үйлдэл рүү хөтөлж, эдгээр барилгуудын дотор болон ойр орчинд хүндэтгэлтэйгээр ярихад хүргэх ёстой. Энэ нь биднийг тэнд байхдаа тодорхой байдлаар зөв хувцаслахад хөтлөх ёстой.

Даруу биш хувцаслалт хийгээд Бурханы хамгийн ариун бүтээл биеэ үл хүндэтгэж байгаа тухай бид ярилаа. Одоо би даруу биш, бүдүүн баараг буюу салан задгай, хайш яайш хувцаслалт, үс засалт хийгээд болж байгаа үйл явдал, эсвэл уг газрын өөрийнх нь ариун нандин чанарыг элэг доог болгож байгаа тухай ярьж байна.

Та нарт нэг жишээ хэлье л дээ. Саявтархан өөр муж улсаас нэг залуу эмэгтэй Солт Лейк Ситигийн бүсэд зарим төрөл төрөгсөдтэйгээ хамт хэдэн долоо хоног амьдрахаар иржээ. Эхний Ням гарагт тэр эмэгтэй энгийн, аятайхан цамц, өвдгөөр татсан урт юбка, товчилдог, цайвар өнгийн битүү захтай ноосон цамц өмсөж сүмд ирэв. Тэр оймс, палаажин дээр өмсдөг ботинктой, үсээ энгийн байдлаар гэвч нямбай самнасан байв. Түүний гадаад төрх байдал залуу насны цогжавхааг илтгэн харуулж байлаа.

Харамсалтай нь, тэр эмэгтэй тэр даруйд эвгүйрхжээ. Түүний насны болон түүнтэй ойролцоо насны бүх эмэгтэйчүүд энгийн бор баарагхан, зарим нь өвдөгнөөс дээш татсан юбка, бариухан богино ханцуйтай цамц, юбканых нь дээд хэсэгт нүцгэн бэлхүүс нь харагдсан (зарим нь нүцгэн биен дээрээ өмссөн)

өмсч, богино буюу урт оймсгүй, задгай хөнгөн улавчин шаахай угласан байлаа.

Тэр шинэ охиныг хараад бусад охид шүтээний байрны тухайд, Хүндэтгэлийн Өдрийн тухайд тэдний хувцаслалт хэрхэн тохирохгүй байгааг мэдээд тэр даруйд сайнаар өөрчлөгдөө байх гэж найдаж болох юм. Гэвч тэд тэгсэнгүй харин зочилж ирсэн хэсгийнхээ хувцаслалтын маягт (хэрэв та нар үүнийг ингэж нэрлэж чадвал) тохируулан өөрчилсөн хүн нь нөгөөх зочин байсныг хэлэхэд гунигтай байна.

Ийм хандлага зөвхөн залуу эмэгтэйчүүдээр хязгаарлагдахгүй, ахимаг насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд тэрчлэн залуу эрэгтэйчүүдийг хамарч байгааг харахад сэтгэл зовмоор байна. Хэдэн жилийн өмнө Теннесийд манай шүтээний байр далайн хар салхинд эвдэрч, засвар хийгдэж байх үеэр манай хэсэг Ням гарагуудад болдог Сүмийн үйлчлэлд зориулан нэгэн ахлах сургуулийг ашиглаж байлаа. Өөр сүсэг бишрэлийн нэг цугларагсад тэдний шинэ шүтээний байр баригдаж байхад мөн нөгөөх ахлах сургуулийг ашигладаг байжээ.

Энэ өөр сүсгийн цугларагсад сүмд ямар хувцас өмсөж ирдгийг хараад би багтрах шахдаг байж билээ. Эрэгтэйчүүд нь костном зангиагүй ирдэг байв. Тэд гольф тоглохоор ирсэн юм уу эсвэл тоглохоор явж байгаа юм шиг харагддаг байлаа. Даашинз юм уу энгийн бор бааз өмд, тэр ч байтугай богино гадуур өмднөөс өөр ямар нэгэн хувцас өмссөн эмэгтэй хүнийг олж харах нь хэцүү байв. Тэднийг сургууль уруу сүмийн цуглаанд ирж байгааг нь мэддэггүй байж билээ, харин тэнд ямар нэг спортын арга хэмжээ болж байгаа юм байхдаа гэж боддог байв.

Энэхүү муу үлгэр жишээтэй харьцуулбал манай хэсгийн гишүүдийн хувцаслалт дажгүй сайн байсан хэдий ч, бид тэрхүү доогуур жишиг рүү улам улам халтирч, төдийлөн ялгарахаа больж байна уу даа гэж бодох болж билээ. “Ням Гарагт хамгийн сайнаа” гэсэн холбоо үгийг бид ашигладаг байв. Энэ нь тэдэнд байдаг хамгийн сайхан хувцас гэсэн утгатайг хүмүүс ойлгодог байв. Энэ онцлог хувцас өөр өөр соёл заншил, эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч өөрчлөгдөх хэдий ч, энэ нь тэдний хамгийн сайхан хувцас байх ёстой.

Түүний өргөөнд, ялангуяа Түүний ариун өдөр бидний нөхцөл байдал бидэнд боломж олгож байгаа тэр байдлаар хамгийн их анхааралтай, даруу байдлаар үс зүсээ янзалж, хувцаслаж ирэхгүй байх нь Бурханыг олны өмнө дорд үзсэн хэрэг юм. Перугийн өндөрлөг

газраас ядуу гишүүн сүмд ирэхийн тулд гол гаталж, цагаан цамцан дээр нь шавартай ус үсэрсэн байлаа гэхэд Их Эзэн гомдохгүй нь лавтай.

Гэвч өөрт нь хэрэгтэй бүх хувцас байдаг, мөн сүм рүү хялбархан ирж болох нэгэн үрчийсэн ажлын өмд, богино ханцуйтай цамцтай ирэхийг хараад Бурхан хэрхэн эмзэглэж болох билээ. Би дэлхий даяар аялж явахдаа хамгийн бага хөрөнгө чинээтэй сүмийн гишүүд хүндэтгэлийн өдрийн цуглаануудад өөрсдөдөө байдаг хамгийн сайхан цэвэрхэн хувцсаа өмсөж ирдэг байхад, илүү их боломжтой хүмүүс хайш яайш, тэр ч байтугай салан задгай байдлаар хувцаслан ирдгийг би туршлагаасаа мэдэх билээ.

Хувцаслалт, үс засалт асуудал биш ээ гэж зарим хүмүүс хэлдэг—энэ бол хүний дотор агуулагддаг бодол. Энэ бол үнэхээр хүний дотор агуулагддаг зүйл гэдэгт би итгэдэг ч гэсэн, энэ бол миний санааг зовоодог зүйл. Ариун газруудад, ариун үйл явдлуудад хайш яайш хувцаслана гэдэг хүний дотроо агуулдаг зүйлийн илэрхийлэлт юм. Энэ нь магадгүй бардамнал эсвэл эсэргүүцэл эсвэл ямар нэгэн зүйл билээ, гэвч багаар хэлэхэд, “Би үүнийг ойлгохгүй байна. Ариун нандин зүйл хийгээд бузар булай зүйлийн хоорондох ялгааг би ойлгодоггүй” хэмээн энэ нь өгүүлдэг. Ийм нөхцөлд тэд Их Эзэнээс амархан нүүр буруулан холддог. Тэд өөрсдөдөө байдаг зүйлийн үнэ цэнийг үнэлдэггүй. Тэдний талаар би санаа зовдог. Хэрэв тэд зарим нэгэн ойлголттой болохгүй бол, хэрэв тэд ариун нандин зүйлийн талаар зарим нэгэн мэдрэмжтэй болохгүй бол, хамгийн чухал бүхнээ эцэстээ алдах аюул тэдэнд тохиолдох учиртай. Та нар бол агуу хожмын үеийн өдрүүдийн Гэгээнтнүүд мөн—өөрсдийнхөө хувийг харцгаа.

Эдгээр зарчмууд өөрөө ариун нандин буюу хүндлэл бишрэл хүлээх учиртай зүйлүүд—жишээ нь баптисм, гишүүний баталгаа, томилолтууд, Их Эзэний Үдшийн Зоогийн ариун ёслолыг адисалсан нь, өвчтөнүүдийг адислах зэрэг санваарын ёслолуудад хамаарах үйл ажиллагаа, үйл явдлуудад холбогддог. Санваарын ёслолуудад “бурханлиг чанарын хүч илэрхийлэгддэгийг” (С ба Г 84:20) Сургаал ба Гэрээ бидэнд өгүүлдэг.

“Эдгээр ёслолууд энэ маягаар өгөгдөв . . . түүгээр хүмүүс Бурхан Хүүг хүсэн хүлээж болохын тул буюу, мөн энэ нь түүний жаягийн дүрслэл, өөрөөр хэлбэл энэ нь түүний жаяг, мөн энэ нь тэд өөрсдийн нүглүүдийн ангижралын тулд түүнийг харуулдан хүлээж болохын тул тэд Их Эзэний энхжинд орж болохын тул хийгдэв” гэж Алма хэлсэн байдаг (Алма 13:16).

Эдгээр ёслолуудыг гүйцэтгэдэг болон гэрчилдэг, эсвэл санваарын хийгээд болж байгаа зүйлийн ариун нандин мөн чанарын төлөө хүндлэл үзүүлэн, эдгээрийг хүлээн авдаг хүмүүс аль алиныг нь би эрхэмлэн үнэлдэг.

Ариун ёслолыг гүйцэтгэхэд урт ханцуйтай цамц өмсөж, зангиа зүүдэг санваартнууд, багш нар, диконуудыг би эрхэмлэн үнэлдэг.

Нөхцөл байдал шаардсан үед, өвчтөнийг адислахын тулд цамц зангиа өмсдөг эрэгтэйчүүдийг би эрхэмлэн үнэлдэг. Хүнийг санваартны албан тушаалд томилоход оролцож байгаа хүмүүс уг томилолт ямар өдөр, хаана болж байгаагаас үл хамааран Ням Гарагийн хамгийн сайхан хувцсаа өмссөн хүмүүсийг би эрхэмлэн үнэлдэг. Тэд бүгдээрээ Бурханыг болон тухайн үйл явдлыг эрхэмлэн дээдэлж, хүндлэл бишрэлийг харуулдаг билээ.

Амьдрал оршихуйд ирэхэд энэ нь ариун байдагчлан, мөнх бус амьдрал төгсгөлд ирэхэд энэ нь бас ариун цаг үе байдаг. Түүнчлэн амьдралд тохиолддог хамгийн чухал үйл явдал—гэрлэлт, ялангуяа мөнхийн гэрлэлтэд хүндэтгэлтэй хандах нь мөн адил үнэн гэдэгт би итгэдэг. Энэ шалтгааны учир, хүмүүс үхэл хагацал буюу гэрлэлтгүй холбоотой үйл явдлуудад оролцоходоо үг яриа, хувцаслалт, биеэ авч явах байдал анхаарал хайхрамжгүй, үл хүндэтгэгч буюу хүндлэлд дургүй болж байгаа нь санаа зовоосон асуудал болж байна.

Оршуулах зарим үйлчлэл хөнгөн хуумгай явдал хийгээд тохиромжгүй хошигнолын үйл явдал болж байна. Их Эзэний Цагаатгал болон Амилуулалт түүнчлэн Түүний авралын төлөвлөгөөг зөвхөн дурдах төдий өнгөрдөг атлаа нилээд хязгаарлавал зохих хувь хүний дурсамжууд нэг юм уу хоёр цаг эзлэх явдал байдаг.

Зарим үед хуриман дээр олонтаа хуримын хүлээн авалтууд дээр хүмүүс нэн хайш яайш байдалтай хувцаслан ирж байна. Тэд ажлаасаа цэвэрлэгээ хийхээр буюу тэр өдрийн амралт зугаалганаас ирж байгаа юм шиг байхдаа санаа нь огт зовдоггүй ажээ. Уригдсан хуримаа хүндэтгэхийг багахан ач холбогдолтой гэж тэд үздэгээ хувцаслалтаараа харуулдаг.

Тэдний байгууллагыг хүндэтгэн хүрэм өмсөж, зангиа зүүхийг саяхан өөрийнхөө хамтрагчдаас хичээнгүйлэн гуйж, тэгээд үүнийг биелүүлсэн нэг хүний тэмдэглэлийг би уншлаа. Тэдний үйлчлэл мөн чанартаа шашных бус, харин иргэнийх байсан бөгөөд бид үүнийг ариун гэж нэрлэхгүй, гэвч зарим зүйлд хүндэтгэл үзүүлэх хэрэгтэй тэгээд бидний хувцаслалтын маяг тэрхүү хүндэтгэлийг илэрхийлэх

хэсэг байх ёстой гэдэг зарчмыг тэрээр ойлгож байжээ. “Би чухал хүн учраас бус, харин энэ үйл явдал төдий их ач холбогдолтой байсан учраас” тэрээр илүү их албан ёсоор хувцаслах хэрэгтэй байсан гэж тэр хэлжээ. Түүний энэ үг чухал үнэнийг нотолж байна. Энэ нь үнэхээр бидний тухай биш л дээ. Эрхэм ариун үйл явдал хийгээд газруудыг хүндлэн бишрэх байдлаар үйлдэж, хувцаслах нь Бурханы тухай асуудал юм.

4. Үг Яриа

Өөр нэг асуудал уруу оръё, энэ бол ариун нандин зүйлийн мэдрэмжтэй холбогдох үг ярианы тухай асуудал юм. Бид юу хэлснийхээ төлөө хариуцлага хүлээх вэ гэдэг нь “Бодлогогүй хэлсэн үг бүрийнхээ төлөө хүмүүс шүүлтийн өдөр тайлагнах болно” (Матай 12:36) гэсэн Их Эзэний үгнээс тодорхой харагддаг. Санаа бодол, үг хэлээ хянаж байхыг Хаан Бенжамин бидэнд сэрэмжлүүлсэн бол (Мозая 4:30-ыг үз), наманчлахгүй бол биднийг шүүгдэх үед “үгс маань биднийг буруутгах болно, тийм ээ, . . . ; бид толбогүйгээр эс тогтоогдох болно” (Алма 12:14) гэж Алма тунхагласан байдаг.

Дэлхийн үг ярианд улам бүр болхи, бүдүүлэг хэллэг өсөн нэмэгдэж байгааг та бүгд өөрсдийн туршлагаар мэдэж байгаа хэдий ч, бид өөрсдийгөө энэ загварт хальтран орж хохироход хүргэж болохгүй. Хараал, бүдүүлэг үг хэллэг бол Бурханыг, Христийг мөн Тэдний бүтээлүүдийг элэг доог хийн шоглодог. Аврагчийг Түүний Цовдлолтын үед доромжилсон шиг тийм элэглэлийн гэм буруу бидэнд хэзээ ч байх ёсгүй.

“Түүгээр өнгөрөн явагсад Есүсийг басамжлан доромжилж, толгойгоо сэгсрэн, Өө! Сүмийг устгаад гурав хоногт дахин баригч та,

“Өөрийгөө авраач, наад загалмайнаасаа буугаач.

“Мөн түүнчлэн ахлах тахилч нар хуулийн багш нарын хамт Түүнийг элэглэн дооглож, өөр хоорондоо, Тэр бусдыг аварсан; тэр өөрийгөө аварч чадахгүй.

“Израилын Хаан энэ Христ одоо загалмайнаасаа буул даа, тэгвэл бид хараад итгэе гэж байв. Есүстэй хамт цовдлогдсон тэр хүмүүс ч мөн адил Түүнийг доромжилж байлаа” (Марк 15:29–32).

“Өөрсдийнхөөрөө [Христийг] тэд цовдолж мөн түүнийг нийтийн өмнө ичгүүрт тавьсан нь” (С ба Г 76:35) мөхлийн хөвгүүдийн цээрлүүлэлт юм. Бид иймэрхүү ямар ч зүйлийг үг яриандаа гаргах ёсгүй.

Бид түүний нэрийг эсвэл Түүний нэрээр хөнгөмсгөөр буюу хайхрамжгүйгээр ярьж болохгүй.

Энэхүү заавар хийгээд сэрэмжлүүлгийг бид Сургаал ба Гэрээнд уншдаг:

“Болгоогтун, бибээр Альфа ба Омега, бүр Есүс Христ болой.

“Иймийн тул, миний нэрийг уруулдаа хэрхэн авахад бүх хүмүүн болгоомжлог—

“Учрыг болгоогтун, энэхүү зэмлэл дор байх тэд, Их Эзэний нэрийг хэрэглэх тэд, мөн үүнийг эрх мэдэлгүйгээр дэмий хоосон хэрэглэх тэд олон буйг би үнэнээр хэлнэ. . . .

“Дээрээс ирдэг тэр нь ариун нандин бөлгөө, мөн болгоомжтойгоор, Сүнсний өдөөлтөөр яригддаг байх ёстой, мөн үүнд буруушаалт гэж үгүй, мөн та нар Сүнсийг залбирлаар дамжуулан хүлээн авах болой; иймийн тул, үүнгүйгээр буруушаалт тэнд үлддэг бөлгөө” (С ба Г 63:60–62, 64).

Есүс Христийн нэрийг хэрэглэх эрх мэдэл бидэнд байдаг ч гэсэн, бид үүнийг болгоомжтой хийх ёстой. Түүний нэрийг бас дээрээс ирдэг ариун нандин зүйлийг Сүнсний өдөөлтөөр болгоомжтойгоор ярих ёстой. Бид Сүмд үг хэлэхээр дуудагдах юм уу гэрчлэлээ хуваалцахдаа үүнийг санаж байх ёстой.

Эдгээр нөхцлүүдэд бид “Есүс Христийн нэрээр” төгсгөх ёстойг мэддэг, энэ нь бид өөрсдийн хэлсэн зүйлээ Түүний нэрээр хэллээ гэсэн утгатай юм. Тиймээс, бид ноуг, мөн үүнийг хэрхэн яаж хэлж байгаадаа тусгайлан анхаарч байх ёстой. Мунхаг буюу тэнэг үг хэллэгт зай байх ёсгүй. Энэ бүхнээс гадна, бид Сүнсний өдөөлтөөр ярьж, буруушаалтаас зайлсхийж байхын тулд залбирлаар дамжуулан Сүнсийг эрэлхийлж байх ёстой.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли өөрийн үгийг “Есүс Христийн ариун нэрээр” гэж олонтаа төгсгөдгийг би дурдсан. Та нар ч бас ингэх ёстой гэж би та нарт зөвлөхгүй; энэ бол түүний бодол санаа эсвэл энэ нь бидний хувьд яг тохирох хэвшмэл зүйл байх ёстой гэдэгт би итгэхгүй байна. Харин бошиглогч түүний хувьд ариун нандин зүйл болох Их Эзэний нэрийг хэлэх тухайд хариуцлагаа гүнзгий ухамсарладагт анхаарлаа хандуулахыг би та нарт уриалж байна. Энэ нэрийг тэрбээр хүндэтгэлтэйгээр хэлж, хүндэтгэлтэйгээр хэрэглэдэг нь бидний дагах ёстой жишээ мөн.

5. Бурханлигаар Эмээх нь

Миний сүүлчийн жишээ “бурханлигаар эмээх нь” гэсэн гарчигтай. Бурханаас эмээхийг хүн төрөлхтөнд зөвлөсөн олон хэсгүүд судруудад байдаг. Манай өнөө үед эмээх гэдэг үгийг “хүндлэл” “бишрэл,” эсвэл “хайр” хэмээн ерөнхийд нь хөрвүүлдэг бөгөөд Бурханаас эмээх гэдэг нь Бурханыг хайрлах хайр буюу Түүнийг, мөн Түүний хуулийг хүндлэн дээдлэх гэсэн утгатай юм. Энэ нь зөв уншлага байх нь олон-таа тохиолддог, гэвч зарим үед, Түүний зарлигуудыг зөрчих замаар Бурханыг гомдоохоос эмээх тухай бошиглогчид ярьж байгаа тохиолдолд эмээх нь жинхэнэ утгаараа байдаггүйд би гайхдаг.

Жишээ нь, “Эзэнээс эмээх нь хорон муугаас холдуулна” (Сургаалт Үгс 16:6) гэсэн энэ сургаалт үгийг аваад үзье. Иов бол гэм зэмгүй, шулуун шударга, “Бурханаас эмээдэг, бузар муугаас зайлдаг” (Иов 1:1) хүн байсныг дүрсэлсэн байдаг. Энэхүү хандлагын сайн үлгэр жишээ бол Египет дэх Иосеф байж болно. Потифарын эхнэр түүнд сээтэн хаяхад Иосеф, “Би яаж ийм муухай хэрэг үйлдэж, Бурхандаа нүгэл үйлдэх билээ?” (Эхлэл 39:9) гэж хариулжээ. Бурханы эсрэг нүгэл үйлдэхээс тэр айсан байлаа. Өнөөдөр олон хүн Иосефын хариу үйлдлийг гэнэн гэж үзэж болох юм. Түүний нарийн чамбай байдлыг тэд шоолон инээж болно. Бурханы эсрэг нүгэл үйлдэхийн айдаст өөрсдийгөө байлга.

Бурханы хүслийн төлөө хангалттай санаа тавиагүйг учир Иосеф Смит нэгэнтээ залруулагдаж байв. “Чи Бурханаас илүүгээр хүмүүнээс айх ёсгүй байсан билээ. Хэдийгээр хүмүүн Бурханы зөвлөгөөг үл ойшоон, мөн түүний үгсийг эс хэрэгслээ ч гэсэн—чи итгэлтэй байх ёстой байсан юм” (С ба Г 3:7–8) гэж Их Эзэн түүнд хэлжээ.

Их Эзэнээс эмээх энэхүү айдаст, эсвэл Паулын нэрлэснээр “бурханлиг айдас” (Еврей 12:28) нь Түүнийг дээдлэн бишрэх бидний хүндэтгэлийн нэг хэсэг байх ёстой гэдэгт би захирагддаг. Бусдын санал бодол буюу дарамт шахалт ямар ч байлаа гэсэн бид түүний мэлмийд буруу болох ямар ч зүйлийг хийхээс эмээхээр бид түүнийг тийм байдлаар хайрлаж, хүндлэн дээдлэх ёстой. “Эрт цагийнхны адилаар эхэл мөн бүх зүрх сэтгэлээрээ Их Эзэнд ирэгтүн, мөн түүний өмнө айж мөн сүрдсэнээр өөрсдийн авралыг гүйцээгтүн” (Мормон 9:27) гэж Мороднай биднээс уриалжээ.

Бидний эргэн тойрон дахь дэлхий ерөнхийдөө Бурханыг үл тоомсорлодог учраас Түүний хүслийг

мэдэж, хэрэгжүүлэх бидний үүрэг хариуцлага байнгын юм гэдгийг заримдаа бид амархан мартдаг. Бидний хүн нэг бүр ирээдүйн нэг өдөр өөрийнхөө амьдрал ахуй, бодол санаа, үг яриа тэрчлэн үйл ажиллагааныхаа төлөө Их Эзэний өмнө хариуцлага хүлээх ёстойг ихэнх хүмүүс мэддэггүй, эсвэл үүнд итгэдэггүй. Айдас хийгээд эмээн сүрдэх явдлаар бид өөрсдийн авралыг гүйцэлдүүлж, өдөр тутмын амьдралд гаргадаг шийдвэрүүд хийгээд үйл ажиллагаануудад юу сайн болох тэр зүйлийг бэлтгэх болно.

Бид өөрсдийн хүлээж авсан зүйлээр адислагдсанаараа бид бусад хүмүүсийн хувьд байхгүй тийм сүнслэг байдлаар ахиц дэвшил гаргаж чадна, гэвч бид бас бусад аливаа хүмүүсээс илүүгээр эрсдэл хүлээдэг. Хэрэв бид нүгэл, илүү агуу гэрлийн эсрэг нүгэл үйлдэх юм бол илүү агуу зэмлэл дор байдгаас бид бусдын үйлддэг нүглүүдийг үйлдэж чаддаггүй билээ. Бидний анхаарал халамжид итгэл хүлээлгэн өгсөн ариун нандин зүйлүүдийг бид шалихгүй зүйл гэж үзэж болохгүй, мөн Бурханыг мэддэггүй хүмүүсийн хувьд ч үүнийг гэм зэмгүй гэж үзэх учиргүй.

Хэрэв бид ариун нандин зүйлүүдийг хүндлэн дээдлэхэд ариун журамтай, мэдрэмтгий байх юм бол Бурхан бидний төлөө санаа тавьдаг, бид бүр илүү ихийг хүлээн авах болно. Эс тэгвэл, адислалууд маань бидний буруушаалт болон хувирна. Зөв хандлага буюу загварыг Их Эзэн Сургаал ба Гэрээнд нотлохдоо:

“Иймийн тул, хэрэв тэрээр миний ёслолуудыг дуулгавартай дагах аваас, сүнс нь гэмшдэг, залбирдаг тэрээр, мөнхүү тэрээр надаар хүлээн зөвшөөрөгддөг бөлгөө.

“Хэрэв тэрээр миний ёслолуудыг дуулгавартай дагах аваас, хэл нь даруу хийгээд сэнхрүүлдэг тэрээр, мөнхүү тэрээр Бурханых бөлгөө.

“Мөн дахин, миний сүр хүчин дор дагжин чичрэх тэрээр та нарт миний өгсөн илчлэлтүүд хийгээд үнэнүүдийн дагуу хүчтэй болгогдох болно, мөн магтаалын хийгээд мэргэн ухааны үр жимсийг урагш авчрах болно” (С ба Г 52:15–17).

Коринтонд хандсан Алмагийн эцэг ёсны гуйлтыг хүлээн авагтун: “Өө хүү минь, чамайг Бурханы шударга ёсыг дахин бүү үгүйсгээсэй хэмээн би хүснэ. Бурханы шударга ёсыг үгйсгээд нүглүүдээ хаацайлахыг огтхон ч бүү хичээ; харин чи Бурханы шударга ёс, мөн түүний нигүүлсэл мөн тэсвэр нь зүрх сэтгэлд чинь бүрэн дүүрнээр нөлөөлөхийг зөвшөөр; мөн энэ нь чамайг доош тоос шороо мэт даруу байдалд авчрахыг зөвшөөр” (Алма 42:30).

Сэрэмжлүүлэг

Та бүхэнд хандсан сэрэмжлүүлгийн үгээр би дуусгая. Ариун нандин зүйлүүдийг дээдлэн хүндлэхээ гүнзгийрүүлснээр та нарын ойлголтууд өсдөг. Үүний тухай судрууд “төгс өдрийг хүртэл улам улам хурц” (С ба Г 50:24) гэрэлтэх гэрэл хэмээн өгүүлдэг.

Энэхүү үйл явц түүнчлэн ач ивээлээс ач ивээлд өсөн дэвждэгийг дүрсэлсэн байдаг. Аврагч өөрөө Тэрээр бүрэн байдлыг хүлээн авах хүртлээ ийм байдлаар өсөн дэвшсэн юм, мөн та нар Түүний алхмуудыг дагаж болно (С ба Г 93:12–20-ийг үз).

Энэ бол ариун нандин зүйлүүдийн мэдрэмж та нарыг удирдан хөтлөх тэр газар юм. Гэвч, ариун журам та нарын дотор өсч, мөн та нарт илүү агуу мэдлэг хийгээд ойлголт итгэмжлэгдэхэд та нар эдгээр зүйлүүдэд анхаарал болгоомжтой хандах ёстойг үргэлж санагтун. Дээрээс ирдэг зүйл ариун нандин бөгөөд түүний тухай Сүнсний өдөөлтөөр анхаарал болгоомжтойгоор ярих ёстойг нотолсон судрыг бид өмнө уншсан билээ. Сувдыг бид гахайн өмнө хаях буюу ариун зүйлийг нохдоод өгөх ёсгүйг (3 Нифай14:6; С ба Г 41:6-г үз) Их Эзэн бас нилээд шулуухан зарлигласан байдаг нь ариун нандин зүйлүүдийн үнэ цэнийг эрхэмлэн дээдлэхэд бэлтгэгдээгүй болон тэр ч байтугай тэдгээрийг эрхэмлэн дээдлэхийн оронд эсэргүүцэн дайрч мэдэх хүмүүст уудлан илчлэх буюу ярилцах ёсгүй гэсэн утгатай юм.

Их Эзэний та нарт өгсөн зүйлүүдэд ухаалаг ханд. Энэ бол итгэл юм. Жишээ нь, та нар өөрсдийн патриархийн адислалыг хэнтэй ч хамаагүй хуваалцах ёсгүй.

Ерөнхийлөгч Боид К.Пакер нэгэнтээ зөвлөхдөө:

“Ер бусын сүнслэг туршлагуудынхаа талаар байнга яриад байх нь ухаалаг бус гэдэгт би итгэхэд хүрсэн юм. Ийм туршлагуудыг дотроо анхаарал болгоомжтойгоор хадгалж, зөвхөн бусдыг адислахын тулд тэдгээрийг ашиглахыг Сүнс өөрөө бидэнд өдөөсөн үед л хуваалцаж байх ёстой.

“Бурханы нууцуудыг мэдэх нь олонд өгөгдсөн юм гэсэн хэдий ч, тэдний түүнд хандуулах тэр анхаарал мөн шаргуу байдлын хэрээр хүмүүний үрсэд хайрладаг тэр үгсийн зөвхөн тэр хэсгийн дагуу л бус аваас хуваалцаж үл болно гэсэн чанд хатуу зарли-

гийг тэд хүлээсэн байдаг” (Алма 12:9) гэсэн Алмагийн үгсийг би ямагт санадаг.

“Ерөнхийлөгч [Марион Ж.] Ромни Женевт нэг удаа номлолын ерөнхийлөгчид болон тэдний гэргий нарт зөвлөгөө өгсөн тухай би сонссон. ‘Би мэддэг бүхнээ та нарт ярихгүй. Би мэддэг бүх зүйлээ гэргийдээ ч огт ярьдаггүй, учир нь хэрэв би ариун нандин зүйлүүдийн талаар хэтэрхий хөнгөн хуумгай ярих юм бол, Их Эзэн үүнээс хойш надад итгэхээ болино гэдгийг би мэддэг.’

“Есүсийн төрөлтийн талаар Мариа бурханлиг үйл явдлуудыг гүйцэлдүүлсэн тухай Лукийн хэлсэнчлэн (Лук 2;19-ийг үз), бид ариун нандин зүйлүүдийг зүрх сэтгэлдээ хадгалж, тунгаан бодох учиртай гэдэгт би итгэдэг.” (“*That All May Be Edified*” [1982], 337).

Энэхүү эцсийн бөгөөд хамгийн гайхамшигтай эрин үед илчлэгдсэн хийгээд хамтдаа авчрагдсан бүх зүйлүүд эрхэм нандин хийгээд ариун юм. Сайн мэдээний Сэргээлт Сүм, Есүс Христийн санваартай байгаагаараа бид бараг ухаандаа төсөөлөн бодох аргагүй ариун нандин зүйлүүдийн сан хөмрөг бидний гарт байдаг. Мөн өнгөрсөн үеийн бошиглогчид мөрөөдөж бидний амьдралд ирэх болно хэмээн эгээрэл хүсэл болж байсан гайхамшигтай адислалуудын энэ цаг үед бид төрсөн нь бас л агуу том адислал юм. Бид эдгээр адислалуудыг үл тоомсорлох, эсвэл тэдгээрийг алга болоход хүргэж болохгүй.

Хайхрамжгүй байдалд гулсан орохын оронд, та нарын амьдрал дуулгавартай байдалд яв цав байх нь өсөн нэмэгдэх болтугай. Ариун нандин зүйлүүд, ариун газрууд, ариун үйл явдлуудын учир, гүн хүндэтгэл, бишрэлээ харуулах арга замуудаар та нар бодож сэтгэн, хувцаслаж мөн үйлдэх болно гэдэгт би найдаж байна.

Ариун нандин зүйлүүдийн мэдрэмж тэнгэрээс буух шүүдэр лугаа адил та нарын бодгальд уусан шингэх болтугай гэдэг нь миний залбирал бөлгөө. Егүүтгэгдэж, дараа нь амилсан, одоо амьдардаг, мөн та нарын Гэтэлгэгч Есүс Христэд энэ нь та нарыг ойртуулах болтугай. Тэрбээр та нарыг Өөрийнхөө адил ариун болгож, та нар “дахин тэндээс явахгүйгээр” (Алма 7:25-ыг үз) Түүний хаант улсад суух болтугай. Есүс Христийн нэрээр, амен.